



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/505

Мөрөн сум

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг
зохион байгуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.9, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Мод тарих үндэсний өдөр зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд намрын мод тарих өдрийг 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Намрын “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр мод тарих аж ахуй нэгж байгууллагуудын хуваарь гарган баталж, хуваарийн дагуу аж ахуй нэгж байгууллагуудыг нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид мод тариулж, айл өрх, иргэдийг өргөнөөр хамруулах ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Мод, бутны ач холбогдол, тарьж ургуулах арга технологи, бортоготой мод ургуулах талаар сурталчлах, технологийн зааврын дагуу тарьж ургуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сумдад таригдсан модны ургалтын хувийг тооцож ажиллах, хариуцсан сумдад бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулахад иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудыг шаардлагатай тарьц суулгацаар хангаж, тарьц суулгац худалдах үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг сум дундын Ойн анги, Байгаль орчны газарт тус тус даалгасугай.

4.Намрын мод тарилтын ажлын хүрээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулахад шаардагдах үржил шимт хөрс, өтөг бууц, усалгаа арчилгаа, хашаа хайс, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж, хариуцан ажлыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж сумдын хэмжээнд мод тарих ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн тайлагнаж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (П.Мөнхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

